

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ-НИЙГМИЙН БАЙДЛЫН 2015 ОНЫ МЭДЭЭЛЭЛ

2016.01.10

Алтай хот

Мал аж ахуй: Аймаг мал сүргээ 99.4 хувиар онд оруулж, 945.6 мянган төл 95.9 хувиар бойжуулж, өмнөх оноос мал өсч 2015 оны эцэст 2 сая 922.6 мянган толгой мал, үүний дотор 88.4 мянган адуу, 58.8 мянган үхэр, 34.7 мянган тэмээ, 909.3 мянган хонь, 1 сая 831.2 мянган ямаа тоологдов.

Малын нийт тоо өмнөх оноос 344.4 мянга буюу 13.4 хувиар өссөний дотор адуу 11.6 мянга буюу 15.1 хувь, үхэр 9.5 мянга буюу 19.2 хувь, тэмээ 2.0 мянга буюу 6.1 хувь, хонь 111.1 мянга буюу 13.9 хувь, ямаа 210.3 мянга буюу 13.0 хувиар тус тус өсчээ.

Нийт мал сүргийн дотор ямаа 62.7 хувь, хонь 31.1 хувь, адуу 3.0 хувь, үхэр 2.0 хувь, тэмээ 1.2 хувийг эзэлж, өмнөх оныхоос үхрийн эзлэх хувь 0.1, хонины эзлэх хувь 0.2 пунктээр өсч, харин ямааны эзлэх хувь 0.2 пунктээр, тэмээнийх 0.1 пунктээр тус тус буурсан байна. 2015 оны эцэст өмнөх оныхоос бүх сум нийт малаа 5 төрлөөр нь өсгөжээ. Эрдэнэ(30.4 мян), Тонхил (29.1 мян), Чандмань (25,0), Халиун (23,8 мян), Цээл (23,0 мян), Дэлгэр(22,8 мян) сумуудад малын тоо хамгийн өндөр өсөлттэй байна.

Мөн мянгат малчдын тоо өмнөх оноос 56.0 хувиар өсч 415 боллоо. Үүний дотор 2001-ээс дээш малтай өрх 14, 1500-2000 малтай өрх 49, 1000-1499 малтай өрх 357 байна. Оны эцсийн байдлаар 200-аас дээш мянган малтай 6, 100-аас дээш мянган толгой малтай 10, 90-ээс дээш мянган толгой малтай 1, 80-аас дээш мянган толгой малтай 1 сум байна.

Дэлгэр (236.0), Цогт (222.6), Эрдэнэ (205.0), Халиун (204.9), Баян-Уул (202.7) сум 2015 онд хамгийн олон мал тоолуулж эхний таван байранд орсон байна.

Адуун сүргийн тоогоор Хөхморьт, Тонхил, Баян-Уул, Дарив, Халиун сум, үхэр сүргийн тоогоор Бигэр, Халиун, Цогт, Есөнбулаг, Шарга сум, тэмээн сүргийн тоогоор Төгрөг, Шарга, Халиун, Хөхморьт, Цогт сум, хонин сүргийн тоогоор Тонхил, Дэлгэр, Баян-Уул, Дарив, Халиун сум, ямаан сүргийн тоогоор Эрдэнэ, Цогт, Дэлгэр, Халиун, Цээл сум эхний таван байранд орсон байна.

Хээлтэгч мал, 100 эхийн төл: Хээлтэгч мал өмнөх оноос 13.1 хувиар өсч, оны эцсийн байдлаар төллөх насны хээлтэгч 1 сая 184.1 мянга болж, нийт малын 40.5 хувь, тухайн сүргийн дотор ингэ 32.9, гүү 29.1, үнээ 38.0, эм хонь 42.1, эм ямаа 40.5 хувийг тус тус эзэлж байна. Аймгийн дүнгээр оны эхний төллөх насны 100 эхээс ишиг 90, хурга 94, тугал 85, унага 83, ээлжийн ингэнээс ботго 51-г тус тус бойжуулав. Мөн тайлант онд 21.0 мянган хээлтэгч мал хээл хаяж, 72.7 мянган хээлтэгч мал сувайрч нийт 93.7 мянган малаас төл авч чадсангүй.

Иргэдийн мал: Иргэд 2 сая 915.8 мянган толгой мал тоолуулсан нь аймгийн нийт малын 99.8 хувийг эзэлж байна. Аминдаа малтай 9.6 мянган өрх байгаагийн 6.7 мянга нь малаа байнга малладаг малчин өрх байна. Малтай өрхийн тоо өмнөх оныхоос 1.8 хувиар, 500-аас дээш малтай өрхийн тоо 25.6 хувиар өсч, 500 хүртэлх малтай өрхийн тоо 2.3 хувиар буурсан байна. Харин малчин өрхийн тоо өмнөх оныхоос 222-оор өсч малын тоо нь 320.0 мянгаар нэмэгдсэн дүн гарлаа.

2015 оны байдлаар малтай нэг өрхөд бодод шилжүүлснээр 60 бод буюу 304 толгой мал, малчин нэг өрхөд бодод шилжүүлснээр 75 бод буюу 382 толгой мал тус тус ногдож байна. Малтай нэг өрхөд дунджаар 4 тэмээ, 9 адуу, 6 үхэр, 94 хонь, 190 ямаа ногдож байна. Өмнөх оноос малтай нэг өрхөд ногдох тэмээ, адуу, үхэр тус бүр 1, хонь 10, ямаа 19-өөр тус тус өсчээ.

Иргэдийн хувийн малын бүлэглэлтээс харахад 10 хүртэл толгой малтай 144 өрх, 11-30 толгой малтай 498, 31-50 толгой малтай 562, 51-100 толгой малтай 1268, 101-200 толгой малтай 2114, 201-500 толгой малтай 3262, 501-999 толгой малтай 1334, 1000-1499 малтай 357, 1500-2000 малтай 49, 2001-с дээш малтай 14 өрх байна.

Малчдын соёл ахуйн зарим үзүүлэлт: Аймгийн нийт малчид жилийн дөрвөн улирлын аясаар нүүдэллэж, бэлчээрийн мал аж ахуйгаа маллах явцад соёл ахуйгаа дээшлүүлсээр ирлээ. Тухайлбал: цахилгааны эх үүсгүүртэй өрх 6.0 мянга, сансарын антеннтай өрх 4.8 мянга, телевизортой өрх 5.1 мянга, радиотой өрх 3.2 мянга, гар утастай өрх 5.5 мянга, оёдлын машинтай өрх 4.2 мянга байна.

Шинээр гаргасан, засварласан худаг: Энэ онд инженерийн хийцтэй 22, энгийн уурхайн 8, бүгд 30 худаг шинээр гаргаж, 63 худгийг засварлан ашиглажээ.

Малжуулалтын талаар: Энэ онд 342 өрхийг 12.6 мянган толгой малаар малжуулж, энэ арга хэмжээнд олон улсын хөтөлбөр төслөөс 138.7 сая, орон нутаг болон бусад эх үүсвэрээс 832.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэл: Энэ оны эцсийн байдлаар үр тариа 514.1 тн, үүнээс улаан буудай 299.9 тн, төмс 652.6 тн, хүнсний ногоо 386.4 тн, малын тэжээлийн ургамал 1159.3 тонныг тус тус хурааж аваад байна. Га-гаас үр тариа 15.6, төмс 77.6, хүнсний ногоо 49.6, тэжээлийн ургамал 29.1 цн-ийг тус тус хураажээ. Мөн 5912.8 тн байгалийн хадлан, 190.9 тн гар тэжээл, 1848.8 тн хужир шүү тус тус бэлтгэсэн байна.

Хилийн худалдаа: Хилийн худалдаагаар нийт 50.3 сая ам долларын төмрийн хүдрийн баяжмал гаргаж, цемент, тоосго болон бусад тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл зэрэг 0.8 сая ам долларын бараа материал оруулж ирэв.

Үнэ: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн төвд 2015 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.3 хувь, суурь үеийнхээс 49.6 хувиар өсч, өмнөх сараас 1.4 хувиар буурсан.

Ерөнхий индекс 2015 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 1.4 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 4.2 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ. Тус бүлгийн индекс буурахад тухайн бүлэгт өндөр хувийн жин эзэлдэг махны үнэ 500-1700 төгрөг, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ 100-150, шатахуун 20-260 төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн малчдын орлогын зонхилох хувийг бүрдүүлдэг ямааны ноолуурын үнэ 12 сард 30.0 төгрөгийн ханштай байна.

Аж үйлдвэр: Тайлант хугацаанд Алтай-Улиастай Эрчим хүчний систем, Мандал голомт, Тулга-Алтай, Ентүм, Ундррам-оюу, Шимт дээж, Ундарга-Алтай, Баярт олон, Эрүүл ус, Даянтайшир, Дуурсах-Алтай зэрэг 37 аж ахуйн нэгж, 85 хувиараа үйлдвэрлэл эрхлэгчид үйл ажиллагаа явууллаа.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл оны үнээр 11 тэрбум 735.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 917.1 сая төгрөг буюу 8.5 хувиар өсчээ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 11 тэрбум 95.2 сая төгрөг болж, нийт бүтээгдэхүүн үйлвэрлэлийн 94.5 хувийг борлуулжээ.

Барилга: Барилга угсралт, их засварын нийт 16 тэрбум 132.5 сая төгрөгийн ажил хийж, үүнээс 15 тэрбум 200.6 сая төгрөгийн шинэ барилга, 931.9 сая төгрөгийн их засварын ажлыг гүйцэтгэсэн байна.

Төсвийн орлого: Орон нутгийн төсөвт 53 тэрбум 236.3 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 91.9 хувиар биелүүлж, аймгийн орлогын албан татвар 4 тэрбум 966.2 сая төгрөгийн орлого олж төлөвлөгөөг 92.4 хувиар биелүүлсэн байна.

Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 98.8 хувиар, хөрөнгийн албан татвар 143.5 хувиар, улсын тэмдэгтийн хураамж 118.5 хувиар биелсэн байна. Татварын орлогын төлөвлөгөөг Баян-Уул, Бигэр, Тайшир, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цогт, Цээл, Шарга, Эрдэнэ сумд 1.9-395.1 хувиар давуулж, бусад сумууд 5.7-30.1 хувиар тасалсан байна.

Төсвийн зарлага: Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтийн 90.5 хувийг санхүүжүүлэв. Үүнд цалин хөлс нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 97.0, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 95.6, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 94.7 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн байгууллагууд 23.8 сая төгрөгийн авлагатай, 80.1 сая төгрөгийн өглөгтэй ажиллажээ.

Банкны мөнгөн орлого, зарлага: Бүгд 25 тэрбум 939.4 сая төгрөгийн зузаатгал хийж кассын гүйлгээнээс 363 тэрбум 915.6 сая төгрөг татаж, монгол банкинд 27 тэрбум 401.4 сая төгрөг шилжүүлж, гүйлгээнд 363 тэрбум 722.2 сая төгрөг гаргалаа. Зээлийн өрийн бүх үлдэгдэл 77 тэрбум 515.0 сая төгрөг байгаагаас хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 0.9 хувийг эзэлж байна. Иргэдийн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 13.1 хувиар өсчээ.

Эрүүл мэнд: Энэ онд 1284 эх амаржиж, 1293 хүүхэд амьд төрж, 277 хүн нас барсан байна. 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 17, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 3 тохиолдол тус тус бүртгэгджээ. Бүртгэгдсэн нийт халдварт өвчний 416 тохиолдол байгаа ба үүнээс гепатитын 10 тохиолдол, бэлгийн замаар дамжих халдварт өвчний 297 тохиолдол, сүрьеэгийн 27 тохиолдол, улаан бурханы 37 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Тайлант онд хорт хавдрын 108 тохиолдол бүртгэгдэж уг өвчнөөр 72 хүн нас баржээ. Осол гэмтлийн 799 тохиолдол бүртгэгдэж үүний улмаас 29 хүн нас барсан байна. Эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүд нийт 196.4 мянган хүнд үзлэг хийж, 13.1 мянган хүнийг хэвтүүлэн эмчилж, 99.1 мянган ор хоног ашиглалаа. Энэ онд 41.2 мянган хүнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан 13.0 мянган хүнийг идэвхитэй хяналтанд авч үйлчилсэн байна. Мөн 14.1 мянган удаа түргэн тусламжийн дуудлагад үйлчилсний 2.2 мянга нь алсын дуудлагад үйлчилжээ.

Хүн ам, нийгмийн зарим үзүүлэлт: Иргэний бүртгэлийн мэдээгээр 288 иргэн гэрлэлтээ бүртгүүлж 14 иргэн гэрлэлтээ цуцлуулж, 21 хүүхэд үрчлэгджээ.

Аймгийн дүнгээр бүтэн өнчин 57, хагас өнчин 1.0 мянган хүүхэд, арван найм хүртэлх насны хүүхэдтэй гэр бүлгүй хүн 1.0 мянга, ганц бие өндөр настан өрх 1.2 мянга, өрх толгойлсон 3.0 мянга, хөгжлийн бэрхшээлтэй 2.2 мянган хүн тус тус байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 19.1 хувь нь хөдөлгөөний согогтой, 9.1 хувь нь сонсгол, 3.6 хувь нь хэл ярианы согогтой, 7.4 хувь нь хавсарсан согогтой, 10.3 хувь нь харах эрхтний өөрчлөлттэй, 35.6 хувь нь бусад, 15.0 хувь нь сэтгэцийн эмгэгтэй хүмүүс байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газар: 2015 онд 18 суманд 52 мал эмнэлэг үржлийн үйлчилгээний нэгж ажиллаж цусан халдвартын вакциныг 35.8 мянган бог, 5.8 мянган бод малд боомын вакциныг 4.9 мянган бод, 12 мянган бог малд, дуутын вакциныг 1.3 мянган үхэрт, сахуугийн вакциныг 9.5 мянган адуунд, галзуугийн вакциныг 25 мянган толгой малд, шөвөг ярын вакциныг 220 мянган хурга

ишгэнд, сохор доголын вакциныг 244 мянган толгой малд, ДХХ-ын вакциныг 202.0 мянган толгой малд нийт 760.3 мянган малыг вакцинд хамруулахаас 760.3 мянган толгой малыг хамруулсан. Мөн Монгол мал хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлж байгаа бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд 867.2 мянган толгой малыг хамруулсан.

Паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний туулгалтанд 650.0 мянга, боловсруулалтанд 580.0 мянга, угаалганд 520.0 мянган толгой малыг тус тус хамруулж нийт дүнгээр 1750.0 мянган толгой мал паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулж ажиллав.

Хээлтүүлүүлэгч малын Бруцеллёз өвчины шинжилгээнд 12,4 мянган толгой малыг хамруулсан. Шүлхий өвчний тандах шинжилгээнд 8 сумын 16 багаас 1560 дээжийг авч шинжилгээ хийсэн. 500 адуунд ямын, 500 үхэрт сүрьеэгийн, 3500 бог малд сүүний цагирган урвалын шинжилгээ хийлээ. Асколын шинжилгээнд 500 дээж, хээл хаялт сувайралтад нөлөөлдөг өвчний шинжилгээнд 400 дээж мөн 29 тн мах, 3000 ширхэг өндөг, 2500 л сүүнд мал эмнэлэг ариун цэврийн магадлан шинжилгээ хийж гэрчилгээ олгосон.

Малчдын өвөлжөө, хаваржааны хашаа хороо, бууц буудлын 9820 м2 талбайд мал эмнэлэг ариун цэврийн ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулсан.

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын тушаалаар 2015 онд бог малд ангилалт хийх ажлыг "Хөдөө аж ахуйн маркетинг" төсөлтэй хамтран 5 сумын 21,0 мянган малд үзлэг ангилалт, аттестатчилал явуулж мэдээллийн санд бүртгэсэн.

"Шилмэл мал-2015" үзэсгэлэн худалдаанд 15 сумын малчид нийт адуу 50, үхэр 25, хонь 102, ямаа 73 нийт 250 толгой малтайгаар оролцлоо. Үүнээс: 60 үржлийн шилмэл малыг шалгаруулан алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагнал, шилмэл малын гэрчилгээ олгож урамшуулсан.

Аудитын газар: 2015 онд санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудит 256 гүйцэтгэлийн аудит 9, нийцлийн аудит 6-г тус тус хийлээ.

Аудитаар 27 тэрбум 685.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж аудитын явцад 2 тэрбум 633.0 сая төгрөгийг залруулж, 20 тэрбум 696.6 сая төгрөгийн зөрчилд 533 заалт бүхий албан шаардлага, 89 заалт бүхий зөвлөмж өгч, 1 тэрбум 31.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосоноос өмнөх оноос шилжиж ирсэн актыг оролцуулан 1 тэрбум 333.3 сая төгрөгийн актыг барагдууллаа.

Орон нутгийн төсөвт төлбөрийн актаар 1 тэрбум 333.3 сая төгрөгийн, орон нутгийн орлого нэмэгдүүлэх саналаар 332.1 сая төгрөг, санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний төлбөрөөр 35.0 сая төгрөгийн нийт 1 тэрбум 700.4 сая төгрөгийн орлогыг оруулсан байна.

Мэргэжлийн хяналтын газар: Тус газар давхардсан тоогоор 903 хуулийн этгээд, 1.3 мянган иргэний худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагааг хамарсан мэргэжлийн хяналт шалгалт хийж, 3.7 мянган зөрчил илрүүлсний 54.1 хувийг арилгуулсан байна. Эдгээр зөрчилд 20.4 сая төгрөгийн торгууль тавьж, 100 хувь, барагдуулан, гаргасан дүгнэлт, акт, албан шаардлагынхаа 93.6 хувийг хэрэгжүүлжээ. Нийт 7 байгууллагын үйл ажиллагааг бүрэн, 9 байгууллагын үйл ажиллагааг түр зогсоож, илэрсэн зөрчлийг арилгасан 7 байгууллагын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Хөдөлмөрийн хэлтэс: Энэ онд хөдөлмөр эрхлэхийг хүсч бүртгүүлсэн ажилгүйчүүд 1044 байгаагийн 52.4 хувь буюу 547 нь эмэгтэйчүүд, 59.2 хувь буюу 618 нь 35 хүртэлх насны залуучууд

байна. Эдгээр бүртгүүлсэн ажилгүйчүүдийн 252 нь дээд, 72 нь тусгай дунд, 81 нь мэргэжлийн анхан шатны, 483 нь бүрэн дунд, 112 нь суурь, 35 бага, 9 нь ямар ч боловсролгүй хүмүүс байна. Мэргэжлийн сургалтанд 110 хүн хамрагдаж 23.5 сая төгрөг зарцуулсан байна. Мөн арилжааны банкаар 585.7 сая төгрөгийн зээл олгож 372 ажлын байр гаргасан байна.

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс: Ахмад настны болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх хөнгөлөлт, жирэмсэн болон амаржсан, хүүхэд асарсан, хүүхэд үрчилж авч өсгөсөн, ихэр ба өнчин хүүхэд өсгөсөн, хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэл насны хүүхэд, насанд хүрэгчдэд олгох халамж, байнгын асаргаа шаардлагатай иргэн, ахмад настны хөнгөлөлт, тусламжийг нийт 5.9 мянган хүнд 1 тэрбум 149.8 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр тэтгэмж олгожээ. Мөн алдарт эхийн одонтой 5.0 мянган ээжид 686.4 сая төгрөг, алдар цолтой ахмадуудад 63.9 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Нийгмийн даатгалын хэлтэс: Нийгмийн даатгалын шимтгэлээр 7 тэрбум 343.3 сая, тэтгэврийн санхүүжилтээр 13 тэрбум 832.7 сая, бүгд 21 тэрбум 175.9 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрүүлж, 7.3 мянган хүний 20 тэрбум 15.2 сая төгрөгийн тэтгэврийг бүрэн олголоо. Мөн тэтгэмжинд олговол зохих 1 тэрбум 310.4 сая төгрөг, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын 52.3 сая төгрөгийг тус тус олгосон байна. Ажилгүйдлын тэтгэмжийн 180.4 сая төгрөгийг 240 хүнд олгожээ.

Биеийн тамир, спортын газар: Эхний 3-р улирлын байдлаар нийтийн биеийн тамирын арга хэмжээний хүрээнд 26 тэмцээн уралдаан арга хэмжээ зохион байгуулагдсан ба давхардсан тоогоор 3208 хүн оролцсон байна.

Баруун бүсийн тэмцээнд 4 төрлөөр 51 тамирчин оролцож жү-до бөхөөр алт 2, мөнгөн медаль 3, хүрэл медаль 8, волейболоор алтан медаль 8, мөнгөн медаль 8, үндэсний бөхийн барилдаанаар алтан медаль 6 тус тус авсан байна. Мөн багийн дүнгээр жүдо 3-р байр, үндэсний бөхөөр 1-р байр тус тус эзэлсэн байна.

Улсын аварга шалгаруулах тэмцээнээс шатрын төрөлд алтан медаль 1, таеквондогийн төрөлд алт 2, хүрэл медаль 2-г тус тус авсан байна.

Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс: Тус хэлтсийн хэмжүүрийн лабораторийн ажил цахилгааны хэмжлийн төрлөөр 1 фазын 51 ширхэг, 3 фазын 3 ширхэг цахилгааны тоолуур, хүндийн хэмжлийн төрлөөр хүнсний худалдаа үйлчилгээнд ашиглагдаж байгаа 145 ширхэг жин, 10 туухай, 2 ширхэг лабораторийн жин, даралтын хэмжлийн төрлөөр 37 ширхэг техникийн манометр, 20 ширхэг цусны даралтын аппарат, эзэлхүүн зарцуулалтын төрлөөр 41 шатахуун түгээх станцийн ашиглаж байгаа 68 ширхэг түгээгүүрийн хошуу, 6 ширхэг усны тоолуур, шалгаж 2 тоолуур зэргийг шалгаж ээлжит болон анхдагч баталгаажуулалтанд хамрууллаа.

Засгийн газрын 127-р тогтоолын 1-р хавсралтад заасаг тохирлын баталгаанд заавал хамрагдах бүтээгдэхүүн үйлчилгээний жагсаалтын дагуу 30 хүнсний дэлгүүр, 5 зоогийн газар, баар 2 ШТС-н, 2 зочид буудлын үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийж тохирлын гэрчилгээ олголоо.

Стандартын салбар сан нь 21 аж ахуйн нэгж, иргэнд 27 стандартаар үйлчилж стандартын талаар зөвлөгөө өглөө. Бигэр, Цогт, Баян-Уул сумдын 3 иргэн, Есөнбулаг сумын НИК ШТС-ын салбарт холбогдох стандартуудыг бэлтгэн өгч үйлчиллээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар: Алтай хотод мод тарих аян өрнүүлж 10 сарын 2, 3-ны өдрүүдэд албан байгууллага, аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагууд, иргэд нийт 2 мянга гаруй хүн мод тарих үйлсэд нэгдэж 7130 ширхэг мод тарилаа.

Аймгийн байгалийн дурсгалт газар Ээж хайрхан уулыг түшиглэн бясалгалын аяллыг 10 сарын 10, 11-ны өдрүүдэд зохион байгуулж 200 гаруй хүн оролцлоо. Говийн их дархан цаазат газар байгуулагдсаны 40 жилийн ойд зориулсан “Алтайн өвөр говийн цөлийн гайхамшиг” гэрэл зургийн үзэсгэлэн 10 сарын 13-нд орон нутгийг судлах музейд нээлтээ хийлээ. Монгол бөхөнгийн тархац байршил тоо толгойг тогтоох ажлыг хийж гүйцэтгэхээр 3 баг гарч ажиллан 10 сарын 15-аас 21-ний хооронд тооллого хийлээ. 2015 оны гадаргын усны тооллогын дүнг урьдчилсан байдлаар нэгтгэн гаргалаа. Тооллогоор гол 335, нуур тойром 109, булаг 1136, рашаан 2, баянбүрд 29, хөв цөөрөм 46, услалтын систем 13, худаг 2015 тоологдлоо.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар: Өссөн дүнгээр аймгийн хэмжээнд 5916 иргэнд 563.6 га газрыг өмчлүүлсэн байна. Мөн гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газраа өмчилж авсан 34 өрхийн гэр бүлийн хэлцлийг үндэслэн 99 иргэний шинээр газар өмчилж авах эрхийг үүсгэж өгсөн. Гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газраа өмчилж авсан 489 өрхийн гэр бүлийн хэлцлийг үндэслэн 1465 иргэний шинээр газар өмчилж авах эрхийг үүсгэж өгсөн.

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар эзэмшүүлэхээр 13 сумд 2437 иргэнд 187.1 га газар төлөвлөснөөс 152 иргэнд 21.2 га газар эзэмшүүлж төлөвлөгөөний биелэлт 85.9% биелэсэн байна.

Гэр бүлийн хэрэгцээнд төмс, хүнсний ногоо тариалах зориулалтаар 11 сумд 48 иргэн, ААНБ-д 166.5 га газар эзэмшүүлэхээр төлөвлөснөөс 35 иргэн, ААНБ-д 165.8 га газар эзэмшүүлж төлөвлөгөөний биелэлт 89.1% биелэсэн байна.

Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар 18 сумд 5.67 га газрыг 48 байршилд эзэмшүүлэхээр төлөвлөснөөс 31 байршилд 3.79 га газрыг эзэмшүүлсэн ба төлөвлөгөөний биелэлт 58.9%-тай байна.

Төсөвт байгууллагын хэрэгцээнд зориулан эзэмшүүлэхээр 11 сумд 19 байршилд 1518.6 га газар төлөвлөснөөс 15 байршилд 1518.5 га газар эзэмшүүлж төлөвлөгөөний биелэлт 95.8% биелэсэн байна.

Ерөнхий боловсролын сургуулиуд: Ерөнхий боловсролын 28 сургууль, 28 цэцэрлэгт өсвөр үеийг сурган хүмүүжүүлж байна. Эдгээр сургуулиудад 11.4 мянган сурагч суралцаж, цэцэрлэгт 4.5 мянган хүүхэд хүмүүжиж байна. Энэ хичээлийн жилд нэгдүгээр ангид 1212 хүүхэд, арван хоёрдугаар ангид 831 хүүхэд тус тус элсэн суралцаж байна.

АШУҮИС-ийн ГАА дахь Ангаах ухааны сургууль: Нийт ажиллагсад 83, үүнээс багш 53, долоон мэргэжлээр 160 оюутан элсэн сурч байна. Үүнээс их эмч 45, сувилахуй 15, эх барихуй 16, уламжлалт эмчилгээний сувилагч 16, бакалавр сувилагч 26, эм найруулагч 17, лаборант 10, туслах сувилагч 15 тус тус суралцаж байна.

Орон нутгийн өмчийн алба: Жилийн эцсийн байдлаар өмч хувьчлалаар 34.7 сая төгрөгийн орлого, түрээсээр 2.1 сая төгрөгийн орлогыг оруулж нийт 36.8 сая төгрөгийн орлого төсөвт төвлөрүүлэн ажилласан байна. Өмч хувьчлалыг олон нийтэд ил тод нээлттэй явуулах зорилгоор зарыг хуульд заасны дагуу 14, 30 хоног бүр нь зарлаж, аль болох олон нийтийг хамруулах зорилгоор тухайн хувьчлагдах хөрөнгийн зарыг сум орон нутагт нь давхар зарлуулан ажиллажээ.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв: 2015-2016 оны хичээлийн жилд 11 мэргэжлээр 612 суралцагчид сурч, нийт 77 ажилтантай үүнээс мэргэжлийн 33, ерөнхий боловсролын 14 багштай ажиллаж байна.

Тэгш-Алтай: Авто машины жолоочийн дамжаагаар 62 хүнд “В” ангиллын жолооч мэргэжил эзэмшүүллээ.

Батлан Хамгаалахад туслах Нийгэмлэг: Авто машины жолоочийн дамжаагаар 33 хүнийг “В” ангиллаар, “С” ангиллаар 14 хүнд жолооч мэргэжил эзэмшүүллээ.

Ихэс-Алтай: Авто машины жолоочийн дамжаагаар 36 хүнд “В” ангиллын жолооч мэргэжил эзэмшүүллээ.

НИК петровис ГА салбар: 4 тэрбум 588.6 сая төгрөгийн шатахуун тосолгооны материалыг татан авч 6 тэрбум 292.1 сая төгрөгийн шатахуун тосолгооны материалын борлуулалт хийлээ.

Цахилгаан холбоо компани: Суурин телефон цэгийн тоо 790, холбоо ашиглалтын орлого 198.7 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 137.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Интернэтийн үйлчилгээний нэг цэгийн 20-н суудалтай ажиллаж интернэтээр дунджаар 6.8 мянган хүнд үйлчилжээ.

Мобиком корпорацийн Говь-Алтай дахь салбар: Тус салбар энэ оны эхний хагас жилийн байдлаар үндсэн хэрэглэгч 1.1 мянга, урьдчилсан төлбөрт карт эзэмшигч 23.1 мянга, бүгд 24.2 мянган хэрэглэгчтэй байна.

Юнител ХХК-ний Говь-Алтай дахь салбар: Тус салбар нь үндсэн хэрэглэгч 0.8 мянга, урьдчилсан төлбөрт карт эзэмшигч 24.5 мянга, бүгд 25.3 мянган хэрэглэгчтэй байна.

Ж-Мобайл ХХК-ний Говь-Алтай дахь салбар: Тус салбар нь дараа төлбөрт 1.0 мянга, урьдчилсан төлбөрт 26.2 мянган хэрэглэгчтэй болоод байна.

Аймгийн “Олон нийтийн Алтай радио” редакци: Энэ улиралд 29 удаагийн нийт 870 минутын нэвтрүүлэг бэлтгэн цацаж 150.0 мянган төгрөгийн орлоготой ажиллажээ.

Миний нутаг телевиз: Мэдээ, сонины тоймыг 92 цаг, хүүхэлдэйн болон уран сайхны киног 420 цаг, зар сурталчилгааг 42 цаг, захиалгат болон шууд нэвтрүүлгийг 112 цаг цацан гаргасан байна.

Дэлхийн зөн: Энэ улиралд 6 төсөл хөтөлбөрийн хүрээнд бэлэг, тусламж, тэмдэглэлт өдөр, сургалт, тохижилтын ажил явуулж нийт 91 сая 610.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс: НҮБ-ийн Хүүхдийн эрхийн конвенци батлагдсаны 26 жилийн ойн хүрээнд эцэг эх, хүүхэд, гэр бүлд чиглэсэн 3 сургалт, 1 хэлэлцүүлэг, 1 телевизийн нэвтрүүлэг, 2 уулзалт, хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийн үр дүнг сурталчлах бусад арга хэмжээнүүдийг нийт 3000 гаруй хүнийг хамруулан 16 байгууллагатай хамтран зохион байгууллаа.

Залуучуудын хөгжлийн төвийн зөвлөгөө өгөх танхимаар нийт 12 хүн үйлчлүүллээ.

Ардын дуу Бүжгийн “Алтай” чуулга: Нийт 17 удаагийн тоглолт үзвэр хийж, 5.3 мянган үзэгчид үзэж нийт 6.4 сая төгрөгийн орлоготой ажилласан.

Аймгийн музей: Үнэт, ховор түүх дурсгал, эд өлгийн 2.5 мянган үзмэрээр 4.1 мянган үзэгчдэд үйлчилж 2.0 сая төгрөгийн орлоготой ажиллав.

Аймгийн нийтийн номын сан: Шинээр 1500 уншигч бүртгэж, 14.0 мянган уншигчид 11 нэр төрлийн хэвлэл, 23.0 мянган номоор үйлчилж, төсвийн хөрөнгөөр 315, хандиваар 977, нөхөн бүрдүүлэлтээр 110, нийт 1402 ширхэг номоор баяжилт хийн уншигчдын эрэлт хэрэгцээг ханган шинэ мэдээ мэдээллээр түргэн шуурхай үйлчилсэн байна.

Онцгой байдлын газар: Энэ онд галын дуудлаганд 37 удаа гарч, 14.5 мянган айл өрх, 359 объектод урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж зөвлөгөө өгч, 245.9 сая төгрөгийн хөрөнгийг гал түймрээс аварчээ. Хүмүүсийн болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалж гал түймрийн улмаас 172.0 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирлаа. Тус 37 удаагийн гал түймэр гарсны 23-ийг нь тус хэлтэс, үлдсэн 14 түймрийг иргэд өөрсдөө унтраасан байна.

Гамшгийн мэдээ: Онцгой байдлын эрэн хайх, аврах бүлэг 73 удаа техникийн болон ослын холбогдолтой дуудлага хүлээн авч ажилласан байна.


Гэмт хэрэг: Байгууллага, иргэдийн 336.4 сая төгрөгийн өмч хөрөнгөнд хохирол учруулж, 210 гэмт хэрэг гарч, эдгээр хэргүүдээс хулгай гэмт хэрэг, үүнээс тээврийн хэрэгсэл болон орон байрны хулгай, хүчин, дээрэм булаалтын гэмт хэргүүд дийлэнх хувийг эзэлж байна. Гарсан нийт хэргийн 58.0 хувь нь Есөнбулаг сумд гарсан хэрэг эзэлж байна.

Гэмт хэрэгт холбогдогч хүмүүс өмнөх оны мөн үеэс урьд нь шийтгүүлсэн хүн, эмэгтэй хүн, хүүхэд 2 дахин, ажил мэргэжилгүй хүмүүс таваар нэмэгдсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба: Энэ онд 499 гүйцэтгэх хуудасны 1 тэрбум 376.4 сая төгрөгийн төлбөрт шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа явуулж үүнээс 487 гүйцэтгэх хуудасны 1 тэрбум 232.8 сая төгрөгийн төлбөрийг биелүүлэхээс 298 гүйцэтгэх хуудасны 199.2 сая төгрөгийн төлбөрийг бодитойгоор биелүүлж, 189 гүйцэтгэх хуудасны 1 тэрбум 33.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй. Гүйцэтгэх хуудасны 61.2 хувийг бодитойгоор биелүүлсэн байна. Хүүхдийн тэтгэлэг төлөгчийн 131 гүйцэтгэх хуудасны 78.7 сая төгрөгийг биелүүлэхээс 4 гүйцэтгэх хуудасны 64.4 сая төгрөгийг биелүүлсэн. 127 гүйцэтгэх хуудасны 14.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй. 81.8 хувийн биелэлттэй байна.

Хорих ялтай ялтны 56 гүйцэтгэх хуудасны 117.3 сая төгрөгийн төлбөр хохирол гаргуулахаар шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа явуулж хорих ангиудад суутгалын бичиг явуулсан 1 гүйцэтгэх хуудасны 800 мянган төгрөгийн төлбөр хүлээн авагчийн хүсэлтээр буцааж, 7 гүйцэтгэх хуудасны 7.8 сая төгрөгийг биелүүлэн 49 гүйцэтгэх хуудасны 109.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.


Нэгдүгээр сарын цаг агаарын урьдчилсан мэдээ: Энэ сарын агаарын температурын дундаж нь нутгийн хойд хэсгээр 24-32 градус, Говь-Алтайн өмнөд хэсгээр 12-17 градус, бусад нутгаар 19-24 градус хүйтэн буюу ихэнх нутгаар олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар дулаан байна /3 дугаар зураг/.



3 дугаар зураг. 1 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан мэдээ

Нэгдүгээр арав хоногийн эхэн ба сүүл, гуравдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар хүйтний эрч суларч Говь-Алтайн өмнөд хэсгээр шөнөдөө 13-18 градус, өдөртөө 0-5 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 20-25 градус, өдөртөө 8-13 градус хүйтэн байна. Харин нэгдүгээр арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн сүүлийн хагаст хүйтний эрч чангарч Алтайн өвөр говиор шөнөдөө 22-27 градус, өдөртөө 12-17 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 29-34, өдөртөө 18-23 градус хүйтэн байна. Алтайн өвөр говиор шөнөдөө 17-22 градус, өдөртөө 7-12 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 24-29 градус, өдөртөө 14-19 градус хүйтэн байна.

Энэ сард орох цасны хэмжээ нь ихэнх нутгаар дунджийн орчим байх төлөвтэй/4 дүгээр зураг/.



Нэг ба хоёр, гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар, хоёр ба гуравдугаар арав хоногийн эхээр нутгийн хойд хэсгээр цас орж цасан шуурга шуурна. Энэ үеэр салхи зарим газраар 12-14 м/с, зарим үед Алтайн уулархаг нутгаар 16-18 м/с хүрч ширүүсэх төлөвтэй.

4 дугаар зураг. 1 дүгээр сард орох хур тунадасны урьдчилсан мэдээ

МАЛ ТООЛЛОГЫН ДҮН
NUMBER OF LIVESTOCK

Сум	Өмнөх онд тоологдсон мал <i>Number of livestock /previous year/</i>						2015 онд тоологдсон мал <i>Number of livestock /current year/</i>					
	Бүгд <i>Total</i>	Тэмээ <i>camel</i>	Адуу <i>horse</i>	Үхэр <i>cattle</i>	Хонь <i>sheep</i>	Ямаа <i>goat</i>	Бүгд <i>Total</i>	Тэмээ <i>camel</i>	Адуу <i>horse</i>	Үхэр <i>cattle</i>	Хонь <i>sheep</i>	Ямаа <i>goat</i>
Алтай	74849	2077	1597	1243	12363	57569	85835	2148	1953	1653	14739	65342
Баян-Уул	185612	1600	6526	3678	68632	105176	202739	1647	7031	4052	75316	114693
Бигэр	132282	1714	3976	4572	32800	89220	149155	1842	4321	5404	36852	100736
Бугат	99295	1109	2400	1114	30690	63982	121349	1157	2976	1418	38628	77170
Дарив	148250	1441	5997	3072	54909	82831	164559	1546	6632	3458	62062	90861
Дэлгэр	213197	1818	4963	3141	74548	128727	236000	1968	5756	3890	81744	142642
Жаргалан	123954	792	2992	2754	43031	74385	139620	808	3472	3347	47770	84223
Тайшир	86021	429	2640	1643	31075	50234	98480	466	3052	2168	36347	56447
Тонхил	172717	350	6697	2596	82274	80800	201809	402	7884	3097	94998	95428
Төгрөг	117881	4709	4464	1766	40861	66081	134794	4901	4997	2047	47578	75271
Халиун	181138	3048	5419	4373	52581	115717	204958	3258	6225	5000	61699	128776
Хөхморьт	108008	2425	7226	3228	36329	58800	122465	2631	7993	3625	40718	67498
Цогт	207298	2304	3298	3773	54787	143136	222601	2432	3607	4483	56126	155953
Цээл	142868	1318	3957	2791	31588	103214	165880	1478	4704	3430	38338	117930
Чандмань	139522	903	3360	1631	47863	85765	164567	1006	4047	2098	56087	101329
Шарга	123613	4161	4125	3843	24411	87073	138038	4428	4597	4299	28562	96152
Эрдэнэ	174623	1748	2442	734	32314	137385	205003	1780	2998	928	38038	161259
Есөнбулаг	146995	814	4670	3399	47192	90920	164719	844	6124	4425	53710	99616
ДҮН /total/	2578123	32760	76749	49351	798248	1621015	2922571	34742	88369	58822	909312	1831326

Сум	Харьцуулсан хувь /Percentage/						Зөрүү /Difference/					
	Бүгд <i>Total</i>	Тэмээ <i>camel</i>	Адуу <i>horse</i>	Үхэр <i>cattle</i>	Хонь <i>sheep</i>	Ямаа <i>goat</i>	Бүгд <i>Total</i>	Тэмээ <i>camel</i>	Адуу <i>horse</i>	Үхэр <i>cattle</i>	Хонь <i>sheep</i>	Ямаа <i>goat</i>
Алтай	114.7	103.4	122.3	133.0	119.2	113.5	10986	71	356	410	2376	7773
Баян-Уул	109.2	102.9	107.7	110.2	109.7	109.0	17127	47	505	374	6684	9517
Бигэр	112.8	107.5	108.7	118.2	112.4	112.9	16873	128	345	832	4052	11516
Бугат	122.2	104.3	124.0	127.3	125.9	120.6	22054	48	576	304	7938	13188
Дарив	111.0	107.3	110.6	112.6	113.0	109.7	16309	105	635	386	7153	8030
Дэлгэр	110.7	108.3	116.0	123.8	109.7	110.8	22803	150	793	749	7196	13915
Жаргалан	112.6	102.0	116.0	121.5	111.0	113.2	15666	16	480	593	4739	9838
Тайшир	114.5	108.6	115.6	132.0	117.0	112.4	12459	37	412	525	5272	6213
Тонхил	116.8	114.9	117.7	119.3	115.5	118.1	29092	52	1187	501	12724	14628
Төгрөг	114.3	104.1	111.9	115.9	116.4	113.9	16913	192	533	281	6717	9190
Халиун	113.2	106.9	114.9	114.3	117.3	111.3	23820	210	806	627	9118	13059
Хөхморьт	113.4	108.5	110.6	112.3	112.1	114.8	14457	206	767	397	4389	8698
Цогт	107.4	105.6	109.4	118.8	102.4	109.0	15303	128	309	710	1339	12817
Цээл	116.1	112.1	118.9	122.9	121.4	114.3	23012	160	747	639	6750	14716
Чандмань	118.0	111.4	120.4	128.6	117.2	118.1	25045	103	687	467	8224	15564

Шарга	111.7	106.4	111.4	111.9	117.0	110.4	14425	267	472	456	4151	9079
Эрдэнэ	117.4	101.8	122.8	126.4	117.7	117.4	30380	32	556	194	5724	23874
Есөнбулаг	112.1	103.7	131.1	130.2	113.8	109.6	17724	30	1454	1026	6518	8696
ДҮН /total/	113.4	106.1	115.1	119.2	113.9	113.0	344448	1982	11620	9471	111064	210311

**ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ДҮН
NUMBER OF BREEDING STOCK**

Сумын нэр	Өмнөх он /previous year/						2014 он /current year/					
	бүгд Total	ингэ female camel	гүү mare	үнээ cow	эм хонь ewe	эм ямаа female goat	бүгд Total	ингэ female camel	гүү mare	үнээ cow	эм хонь ewe	эм ямаа female goat
Алтай	26049	672	401	389	4352	20235	29103	611	416	430	4948	22698
Баян уул	66836	430	1556	1130	25171	38549	73056	444	1837	1346	28135	41294
Бигэр	44304	474	963	1360	11100	30407	51038	548	1161	1717	12820	34792
Бугат	33997	280	588	345	10381	22403	40373	306	700	432	13012	25923
Дарив	58779	463	1579	993	21826	33918	64224	478	1697	1187	24313	36549
Дэлгэр	75232	540	1255	1061	27294	45082	86969	553	1371	1136	31566	52343
Жаргалан	41043	223	596	789	14573	24862	50122	258	767	1069	17912	30116
Тайшир	30669	157	594	520	10996	18402	36025	163	755	692	13471	20944
Тонхил	62429	70	1885	882	30912	28680	71656	81	2184	970	35950	32471
Төгрөг	43876	1520	1109	557	15104	25586	48739	1628	1316	714	17343	27738
Халиун	66894	953	1405	1480	19478	43578	75886	1039	1620	1757	23254	48216
Хөхморьт	33864	514	1495	913	11644	19298	40535	523	1722	1082	14327	22881
Цогт	78071	692	852	1280	20744	54503	84907	748	980	1455	22091	59633
Цээл	52362	345	925	825	11428	38839	59726	393	1149	1024	13741	43419
Чандмана	46448	288	780	493	16549	28338	51554	269	889	538	18089	31769
Шарга	45849	1530	1036	1215	8940	33128	51525	1623	1231	1575	10638	36458
Эрдэнэ	58306	464	525	233	10849	46235	68301	465	695	268	13034	53839
Есөнбулаг	50785	255	1208	1101	17109	31112	63168	285	1523	1384	21050	38926
ДҮН	915793	9870	18752	15566	288450	583155	1046907	10415	22013	18776	335694	660009

Сумын нэр	Харьцуулсан хувь /percentage/						2013 оноос зөрүү /difference/					
	Бүгд Total	Тэмээ camel	Адуу horse	Үхэр cattle	Хонь sheep	Ямаа goat	Бүгд Total	Тэмээ camel	Адуу horse	Үхэр cattle	Хонь sheep	Ямаа goat
Алтай	111.7	90.9	103.7	110.5	113.7	112.2	3054	-61	15	41	596	2463
Баян уул	109.3	103.3	118.1	119.1	111.8	107.1	6220	14	281	216	2964	2745
Бигэр	115.2	115.6	120.6	126.3	115.5	114.4	6734	74	198	357	1720	4385
Бугат	118.8	109.3	119.0	125.2	125.3	115.7	6376	26	112	87	2631	3520
Дарив	109.3	103.2	107.5	119.5	111.4	107.8	5445	15	118	194	2487	2631
Дэлгэр	115.6	102.4	109.2	107.1	115.7	116.1	11737	13	116	75	4272	7261
Жаргалан	122.1	115.7	128.7	135.5	122.9	121.1	9079	35	171	280	3339	5254
Тайшир	117.5	103.8	127.1	133.1	122.5	113.8	5356	6	161	172	2475	2542
Тонхил	114.8	115.7	115.9	110.0	116.3	113.2	9227	11	299	88	5038	3791
Төгрөг	111.1	107.1	118.7	128.2	114.8	108.4	4863	108	207	157	2239	2152
Халиун	113.4	109.0	115.3	118.7	119.4	110.6	8992	86	215	277	3776	4638
Хөхморьт	119.7	101.8	115.2	118.5	123.0	118.6	6671	9	227	169	2683	3583
Цогт	108.8	108.1	115.0	113.7	106.5	109.4	6836	56	128	175	1347	5130
Цээл	114.1	113.9	124.2	124.1	120.2	111.8	7364	48	224	199	2313	4580
Чандмана	111.0	93.4	114.0	109.1	109.3	112.1	5106	-19	109	45	1540	3431
Шарга	112.4	106.1	118.8	129.6	119.0	110.1	5676	93	195	360	1698	3330
Эрдэнэ	117.1	100.2	132.4	115.0	120.1	116.4	9995	1	170	35	2185	7604

Есөнбулаг	124.4	111.8	126.1	125.7	123.0	125.1	12383	30	315	283	3941	7814
ДҮН	114.3	105.5	117.4	120.6	116.4	113.2	131114	545	3261	3210	47244	76854

ТӨЛ БОЙЖИЛТЫН МЭДЭЭ
REARING OF YOUNG ANIMALS

Сум	Soums	Төллөсөн хээлтэгч BREEDING STOCK						Хорогдсон төл LOSSES OF YOUNG ANIMALS					
		Бүгд Total	ингэ female camel	гүү mare	үнээ cow	эм хонь ewe	эм ямаа female goat	Бүгд total	ботг о female camel	унаг а mare	туга л cow	хурга а ewe	ушиг г female goat
1.Алтай	Altai	27527	344	376	421	5198	21188	985	71	49	49	287	529
2.Баян-Уул	Bayan-Uul	58221	213	1468	1061	23369	32110	2550	9	55	27	730	1729
3.Бигэр	Biger	45365	255	908	1404	11660	31138	2613	16	83	47	775	1692
4.Бугат	Bugat	41020	156	657	472	13465	26270	859	11	46	22	130	650
5.Дарив	Dariv	57874	218	1454	1030	22606	32566	816	10	57	30	298	421
6.Дэлгэр	Delger	85920	292	1353	1136	31193	51946	448	3	12	10	90	333
7.Жаргалан	Jargalan	40500	136	523	726	15358	23757	855	2	4	11	286	552
8.Тайшир	Taishir	35716	86	674	639	13504	20813	803	3	14	9	198	579
9.Тонхил	Tonhil	72300	48	1902	903	36930	32517	1129	12	157	64	361	535
10.Төгрөг	Tugrug	46368	967	1239	679	16689	26794	1861	2	41	37	508	1273
11.Халиун	Haliun	70100	511	1276	1521	23133	43659	7425	39	138	57	1917	5274
12.Хөхморьт	Huhmorit	39762	283	1660	1064	14206	22549	0	0	0	0	0	0
13.Цогт	Tsogt	76864	341	844	1292	20741	53646	1172					
14.Цээл	Tseel	55715	212	1093	946	13153	40311	4	26	232	317	2201	8948
15.Чандмань	Chandmani	51488	149	875	524	18032	31908	1789	28	172	84	295	1210
16.Шарга	Sharga	47825	864	1005	1302	10445	34209	814	4	3	0	324	483
17.Эрдэнэ	Erdene	68614	257	687	281	12819	54570	1726	17	74	68	366	1201
18.Есөнбулаг	Yesunbulag	62361	214	1450	1381	21394	37922	2341	15	17	9	412	1888
		62361	214	1450	1381	21394	37922	1677	4	49	59	594	971
ДҮН	Total	9835		1944	1678	3238	6178	4041		120		977	2826
	40	5546	4	2	95	73	5	272	3	900	2	8	
	Previous year	72852		1333	1130	23546	46366	2726					1974
12/31/2013	year	4	4754	5	9	0	6	7	357	877	403	5890	0

Сум	Soums	Бойжсон төл Young surviving animals						Бойжилтын хувь Survival percentage					
		Бүгд Total	ботг о colt	унаг а foals	туга л calves	хурга а lambs	ушиг г kids	Бүгд Total	ботг о colt	унаг а foals	туга л calves	хурга а lambs	ушиг г kids
1.Алтай	Altai	26516	242	327	372	4916	20659	96.4	77.3	87.0	88.4	94.5	97.5
2.Баян-Уул	Bayan-Uul	55707	210	1413	1034	22657	30393	95.6	95.9	96.3	97.5	96.9	94.6
3.Бигэр	Biger	42786	273	825	1357	10885	29446	94.2	94.5	90.9	96.7	93.4	94.6
4.Бугат	Bugat	40222	204	611	450	13335	25622	97.9	94.9	93.0	95.3	99.0	97.5
5.Дарив	Dariv	57377	239	1397	1000	22541	32200	98.6	96.0	96.1	97.1	98.7	98.7
6.Дэлгэр	Delger	85338	145	1341	1126	31113	51613	99.5	98.0	99.1	99.1	99.7	99.4
7.Жаргалан	Jargalan	39976	208	519	716	15158	23375	97.9	99.0	99.2	98.5	98.1	97.7
8.Тайшир	Taishir	35570	289	660	630	13509	20482	97.8	99.0	0.0	98.6	98.6	97.3
9.Тонхил	Tonhil	71491	134	1745	839	36685	32088	98.4	0.0	0.0	92.9	99.0	98.4
10.Төгрөг	Tugrug	43630	83	1198	642	16181	25526	95.9	97.6	96.7	94.6	97.0	95.2
11.Халиун	Haliun	62954	36	1138	1464	21514	38802	89.4	48.0	89.2	96.3	91.8	88.0
12.Хөхморьт	Huhmorit	40444	965	1660	1064	14206	22549	100.0	0.0	0.0	100.0	100.	100.0

БТ		0											
13.Цогт	<i>Tsogt</i>	65320	472	612	975	18548	44713	84.8	94.8	72.5	75.5	89.4	83.3
14.Цээл	<i>Tseel</i>	54072	283	921	862	12885	39121	96.8	91.0	84.3	91.1	97.8	97.0
15.Чандмань	<i>Chandmani</i>	50971	315	872	524	17786	31474	98.4	0.0	0.0	100.0	98.2	98.5
16.Шарга	<i>Sharga</i>	45740	184	931	1234	10217	33174	96.4	91.5	92.6	94.8	96.5	96.5
17.Эрдэнэ	<i>Erdene</i>	66196	145	670	272	12427	52682	96.6	90.6	97.5	96.8	96.8	96.5
18.Есөнбулаг	<i>Yesunbulag</i>	61329	847	1401	1322	20802	36957	97.3	99.5	96.6	95.7	97.2	97.4
		9456		1824	1588	3153	5908						
ДҮН	Total	39	5274	1	3	65	76	95.9	95.1	93.8	94.6	97.0	95.4
12/31/2013	<i>Previous year</i>	70694		1245	1090	23181	44736						
		9	4397	9	9	7	7	96.3	93.3	91.6	94.4	96.8	96.3

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУСЫН ХОРОГДЛЫН МЭДЭЭ /багаар/

Сум	Багийн нэр	Хорогдсон том мал						Өвчнөөр хорогдсон том мал						Хорогдсон хээлтэгч мал					
		Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Есөнбулаг сум	1-р баг, Баянхайрхан	71	0	0	0	33	38	17	0	0	0	7	10	31	0	0	0	8	23
	2-р баг, Баяншанд	21	0	0	0	8	13	5	0	0	0	2	3	4	0	0	0	1	3
	3-р баг, Жаргалант	54	0	0	0	25	29	2	0	0	0	1	1	17	0	0	0	8	9
	4-р баг, Харзат	56	3	4	0	18	31	2	0	1	0	0	1	21	0	1	0	8	12
	5-р баг, Рашаант	353	18	16	2	122	195	50	2	6	1	16	25	99	4	2	0	37	56
	6-р баг, Наран	302	5	10	2	109	176	41	3	8	0	18	12	23	0	7	0	6	10
	7-р баг, Жинст	25	0	0	0	8	17	6	0	0	0	3	3	0	0	0	0	0	0
	8-р баг, Индэрт	70	0	0	0	38	32	13	0	0	0	6	7	13	0	0	0	7	6
	9-р баг, Түмэн	94	3	1	0	40	50	8	0	0	0	4	4	45	0	1	0	18	26
	10-р баг, Оргил	28	0	2	0	18	8	8	0	0	0	7	1	3	0	2	0	0	1
	Дүн	1074	29	33	4	419	589	152	5	15	1	64	67	256	4	13	0	93	146
Алтай сум	1-р баг, Бадрал	286	6	17	13	68	182	1	0	1	0	0	0	56	2	3	4	16	31
	2-р баг, Баянцагаан	164	11	8	12	55	78	0	0	0	0	0	33	2	2	1	13	15	
	3-р баг, Урт	276	13	4	12	95	152	0	0	0	0	0	67	3	1	3	23	37	
	4-р баг, Баян-Овоо	214	6	18	3	83	104	18	1	0	0	13	4	102	3	13	1	33	52
		Дүн	940	36	47	40	301	516	19	1	1	0	13	4	258	10	19	9	85
Баян-Уул сум	1-р баг, Баян богд	112	5	2	0	39	66	46	3	2	0	14	27	14	0	0	0	4	10
	2-р баг, Чандмань хайрхан	90	9	1	1	12	67	0	0	0	0	0	0	1	0	1	0	0	0
	3-р баг, Баянхайрхан	333	5	2	0	147	179	4	0	0	0	0	4	183	1	0	0	126	56
	4-р баг, Хүйсийн говь	168	5	3	1	55	104	0	0	0	0	0	0	42	0	0	0	35	7
	5-р баг, Баянговь	722	2	5	4	147	564	44	0	1	3	10	30	79	1	0	2	12	64
	6-р баг, Алтангадас	226	5	2	2	95	122	1	0	0	1	0	0	83	2	0	0	25	56
		Дүн	1651	31	15	8	495	1102	95	3	3	4	24	61	402	4	1	2	202
Бигэр сум	1-р баг, Мянгай	269	12	13	15	108	121	64	4	1	0	25	34	62	2	1	0	27	32
	2-р баг, Урт	573	22	18	4	172	357	33	0	0	0	11	22	67	4	3	1	20	39
	3-р баг, Их булаг	466	39	22	3	136	266	119	7	10	0	30	72	79	3	2	1	21	52
	4-р баг, Буудай	703	14	30	5	82	572	50	3	1	2	7	37	75	3	8	2	22	40
	5-р баг, Хүрэмт	760	19	7	6	256	472	60	3	1	3	22	31	131	2	1	1	49	78
		Дүн	2771	106	90	33	754	1788	326	17	13	5	95	196	414	14	15	5	139
Бугат сум	1-р баг, Биж	0	0	0	0	0	0												
	2-р баг, Ферм	70	6	1	0	8	55	46	0	0	0	6	40	0	0	0	0	0	0
	3-р баг, Гаханч	274	10	3	9	57	195	91	0	0	1	10	80	143	2	0	0	9	132
	4-р баг, Сүж	139	3	3	0	33	100	112	2	3	0	25	82	12	1	0	0	5	6
	5-р баг, Баянгол	15	0	0	1	6	8	1	0	0	1	0	0	11	0	0	0	3	8
	Дүн	498	19	7	10	104	358	250	2	3	2	41	202	166	3	0	0	17	146
Дарив сум	1-р баг, Ихэс	123	3	8	1	26	85	0	0	0	0	0	0	16	0	3	0	5	8
	2-р баг, Хужирт	365	14	12	8	79	252	1	0	0	1	0	0	2	0	1	1	0	0
	3-р баг, Жавхлант	126	3	5	0	32	86	5	0	0	0	2	3	14	0	3	0	4	7
	4-р баг, Үйлдвэр	95	8	11	2	8	66	0	0	0	0	0	0	61	2	7	0	0	52
		Дүн	709	28	36	11	145	489	6	0	0	1	2	3	93	2	14	1	9

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУСЫН ХОРОГДЛЫН МЭДЭЭ /багаар-үргэлжлэл 2/

Сум	Багийн нэр	Хорогдсон том мал						Өвчнөөр хорогдсон том мал						Хорогдсон хээлтэгч мал					
		Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Цогт сум	1-р баг, Рашаант	357	1	0	2	87	267	22	0	0	2	20	0	100	0	0	0	0	100
	2-р баг, Далан	0	0	0	0	0	0												
	3-р баг, Гэгээт	126	0	0	0	0	126	50	0	0	0	50	50	0	0	0	0	0	50
	4-р баг, Төгрөг	796	15	19	24	196	542	0	0	0	0	0	150	0	0	0	0	0	150
	5-р баг, Баян-Өндөр	44	0	0	0	28	16	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	6-р баг, Баян-Улаан	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	7-р баг, Баян тоорой	44	0	7	0	12	25	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Дүн	1368	17	26	26	323	976	72	0	0	2	20	50	300	0	0	0	0	300
Цээл сум	1-р баг, Бүрэн	33	0	0	0	14	19	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	2-р баг, Баянгол	0	0	0	0	0	0												
	3-р баг, Дэрстэй	117	8	19	4	22	64	8	0	2	0	2	4	30	0	3	0	9	18
	4-р баг, Жаргалт	309	6	3	0	75	225	102	0	0	0	29	73	41	2	1	0	8	30
	Дүн	459	14	22	4	111	308	110	0	2	0	31	77	71	2	4	0	17	48
Чандмань сум	1-р баг, Чандмань-Уул	168	0	1	0	60	107	0	0	0	0	0	28	0	1	0	9	18	
	2-р баг, Өлзийбулаг	42	2	0	0	15	25	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
	3-р баг, Эрдэнэ-Уул	146	0	0	0	66	80	0	0	0	0	0	20	0	0	0	7	13	
	4-р баг, Хүрхрээ	98	0	0	0	42	56	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
	Дүн	454	2	1	0	183	268	0	0	0	0	0	48	0	1	0	16	31	
Шарга сум	1-р баг, Баянгол	282	10	37	25	38	172	6	1	1	1	0	3	46	2	4	1	14	25
	2-р баг, Хамтын хүч	318	15	8	8	87	200	19	0	0	0	9	10	12	0	0	0	4	8
